



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/24/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас: 99125777

Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Залруулсан алдаа.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ҮЕНЧ, БОДОНЧ, БУЛГАН ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Б.БАТЗОРИГ ТАНАА

2023.02.01 № 02/04
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт онцлох ажил гүйлгээ байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад Булган сумын ИТХ-ын даргын 2022.12.27-ны өдрийн 14 тоот захирамжаар ОНХС-аар хийгдсэн халаалт дулааны холболт сантехникийн хөрөнгө оруулалт 20.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, бараа ажил үйлчилгээний зардлын санхүүжилт 31.9 сая төгрөгөөр өссөн нь үлэмж нөлөө үзүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Санхүүгийн байдлын тайлан

				/Төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,544,900.0</u>	<u>4,544,900.0</u>		
35	БАРАА МАТЕРИАЛ	4,544,900.0	4,544,900.0		
354	Хангамжийн материал	4,544,900.0	4,544,900.0		
35420	Аж ахуйн материал	4,544,900.0	4,544,900.0		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,460,502.0</u>	<u>27,449,207.5</u>		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,460,502.0	27,449,207.5		
392	Биег хөрөнгө	11,460,502.0	27,449,207.5		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,559,500.0	2,559,500.0		
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,163,083.5)	(2,116,250.2)		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,619,170.0	20,619,170.0		
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,123,099.7)	(17,469,320.0)		
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,717,262.3	11,717,262.3		
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,149,247.2)	(7,861,154.7)		
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	20,000,000.0		
39301	Програм хангамж	48,125.0	48,125.0		
39302	Хуримтлагдсан элэгдэл	(48,125.0)	(48,125.0)		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>16,005,402.0</u>	<u>31,994,107.5</u>		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>16,005,402.0</u>	<u>31,994,107.5</u>		
51	Засгийн газрын хувь оролцоо	16,005,402.0	31,994,107.5		
512	Хуримтлагдсан үр дүн	16,005,402.0	31,994,107.5		
51210	Өмнөх үеийн үр дүн	16,005,402.0	16,005,402.0		
51220	Тайлант үеийн үр дүн	-	15,988,705.5		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>16,005,402.0</u>	<u>31,994,107.5</u>		

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл		

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	161,460,437.0	205,271,600.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,867,637.0	20,000,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	10,867,637.0	20,000,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,867,637.0	20,000,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,867,637.0	20,000,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	150,592,800.0	185,271,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	150,592,800.0	184,571,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	150,592,800.0	184,571,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	700,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	700,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	152,394,541.0	189,282,894.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	152,394,541.0	189,282,894.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	142,463,340.0	150,932,995.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,108,578.1	116,098,316.0
210101	Үндсэн цалин	113,108,578.1	94,546,340.0
210102	Нэмэгдэл	-	15,997,090.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,702,200.0
210104	Урамшуулал	-	1,852,686.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,629,713.0	14,066,373.0
210201	Тэтгэврийн даатгал	10,173,030.0	9,741,737.6
210202	Тэтгэмжийн даатгал	1,063,074.0	1,157,509.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	904,963.0	926,007.6
210204	Ажилгүйдлийн даатгал	226,241.0	218,344.5
210205	Эрүүл мэндийн даатгал	2,262,405.0	2,022,773.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,634,963.0	2,262,412.0
210301	Гэрэл, цахилгаан	239,963.0	306,712.0
210302	Түлш, халаалт	2,395,000.0	1,955,700.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,135,400.0	8,676,400.0
210401	Бичиг хэрэг	256,400.0	103,200.0
210402	Тээвэр, шатахуун	3,213,300.0	6,356,600.0

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.0	1,680,800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	665,700.0	535,800.0
2105	Нормативт зардал	285,100.0	239,600.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	285,100.0	239,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,125,100.0	945,600.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	768,700.0	646,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.0	299,600.0
2107	Томилолт, зочны зардал	1,724,345.0	3,813,000.0
210702	Дотоод албан томилолт	1,724,345.0	3,813,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	715,300.0	573,700.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297,000.0	232,100.0
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.0	54,100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.0	61,900.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.0	15,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.0	210,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,104,841.0	4,257,594.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	293,100.0	246,300.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,811,741.0	4,011,294.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,931,201.0	38,349,899.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	37,804,400.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	37,804,400.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,931,201.0	545,499.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,931,201.0	545,499.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>9,065,896.0</u>	<u>15,988,705.5</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>9,065,896.0</u>	<u>15,988,705.5</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,159,506.0	6,159,506.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,159,506.0	6,159,506.0

C07	Тайлант үеийн үр дүн	8,137,189.5	8,137,189.5
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,005,402.0	16,005,402.0
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,005,402.0	16,005,402.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,005,402.0	16,005,402.0
D08	Тайлант үеийн үр дүн	15,988,705.5	15,988,705.5
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	31,994,107.5	31,994,107.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	150,592,800.0	185,271,600.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	150,592,800.0	185,271,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	150,592,800.0	184,571,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	150,592,800.0	184,571,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	700,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	700,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	150,592,800.0	185,271,600.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,592,800.0	185,271,600.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,661,599.1	146,921,701.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,315,891.1	115,688,189.0
210101	Үндсэн цалин	71,475,297.0	86,624,789.0
210102	Нэмэгдэл	26,018,194.1	25,241,000.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,822,400.0	3,822,400.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,722,200.0	14,476,500.0
210201	Тэтгэврийн даатгал	10,360,100.0	9,843,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,090,500.0	1,158,200.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	872,400.0	926,500.0
210204	Ажил үйлдлийн даатгал	218,100.0	231,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,181,100.0	2,316,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,634,963.0	2,262,412.0

210301	Гэрэл, цахилгаан	239,963.0	306,712.0
210302	Түлш, халаалт	2,395,000.0	1,955,700.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,135,400.0	8,676,400.0
210401	Бичиг хэрэг	256,400.0	103,200.0
210402	Тээвэр, шатахуун	3,213,300.0	6,356,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.0	1,680,800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	665,700.0	535,800.0
2105	Нормативт зардал	285,100.0	239,600.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	285,100.0	239,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,125,100.0	945,600.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	768,700.0	646,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.0	299,600.0
2107	Томилолт, зочны зардал	1,724,345.0	3,813,000.0
210702	Дотоод албан томилолт	1,724,345.0	3,813,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,425,500.0	573,700.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,710,200.0	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297,000.0	232,100.0
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.0	54,100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.0	61,900.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.0	15,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.0	210,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	293,100.0	246,300.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	293,100.0	246,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,931,201.0	38,349,899.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	37,804,400.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	37,804,400.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,931,201.0	545,499.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,931,201.0	545,499.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	184,571,600.0	184,026,101.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	184,571,600.0	184,026,101.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	146,767,200.0	146,221,701.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,811,100.0	115,688,189.0
210101	Үндсэн цалин	86,747,700.0	86,624,789.0
210102	Нэмэгдэл	25,241,000.0	25,241,000.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,822,400.0	3,822,400.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,476,500.0	14,476,500.0
210201	Тэтгэврийн даатгал	9,843,900.0	9,843,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,158,200.0	1,158,200.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	926,500.0	926,500.0
210204	Ажилгүйдлийн даатгал	231,700.0	231,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,316,200.0	2,316,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,373,200.0	2,262,412.0
210301	Гэрэл, цахилгаан	417,500.0	306,712.0
210302	Түлш, халаалт	1,955,700.0	1,955,700.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,976,400.0	7,976,400.0
210401	Бичиг хэрэг	103,200.0	103,200.0
210402	Тээвэр, шатахуун	5,656,600.0	5,656,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,680,800.0	1,680,800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	535,800.0	535,800.0
2105	Нормативт зардал	239,600.0	239,600.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	239,600.0	239,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	945,600.0	945,600.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	646,000.0	646,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	299,600.0	299,600.0
2107	Томилолт, зочны зардал	4,124,800.0	3,813,000.0

210702	Дотоод албан томилолт	4,124,800.0	3,813,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	573,700.0	573,700.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.0	232,100.0
210803	Даатгалын үйлчилгээ	54,100.0	54,100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,900.0	61,900.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,500.0	15,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,100.0	210,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	246,300.0	246,300.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	246,300.0	246,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,804,400.0	37,804,400.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,804,400.0	37,804,400.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,804,400.0	37,804,400.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	184,571,600.0	184,026,101.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	184,571,600.0	184,026,101.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	184,571,600.0	184,026,101.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.0	11.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8.0	7.0
620003	Үйлчлэх ажилтан	3.0	3.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл / төгрөгөөр /
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	700,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	700,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	700,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	700,000.0
210402	Тээвэр, шатахуун	700,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	700,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	700,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,000.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргаа нь “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон усны зохистой ашиглалт, хамгаалалтыг бий болгох замаар сав газрын нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах” гэсэн зорилтыг дэвшүүлэн сав газрын хэмжээнд усны нөөцийн хомсдол, бохирдохоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

БОАЖЯ-ны сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/22 тоот тушаалаар Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааг 11 орон тоотой байхаар баталсан байна. Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргаа нь Дарга 1, Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн 1, усны барилга байгууламж, үйлдвэр хөдөө аж ахуй ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн 1, газрын доорх усны нөөц судалгаа хариуцсан мэргэжилтэн 1, УННМ, сургалт олон нийттэй харилцах мэргэжилтэн 1, цаг уурын эко систем судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн 1, усны чанар төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, нягтлан бодогч 1, гэрээт галч 1, үйлчлэгч галч 1, нярав жолооч 1 нийт 11 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Сав газрын хэмжээнд ус бохирдуулагч иргэн, аж ахуй нэгжийн судалгаа хийж, сав газрын хэмжээнд 108 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус бохирдуулсны дүгнэлт гаргаж, ус бохирдуулсны төлбөрийг ноогдуулан, жагсаалт гаргаж, Усны газарт хүргүүлсэн байна.

Жимс, жимсгэний мод үржүүлэх ажил, газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн газрын хэмжээ болон модны тоог нь тогтоон, судалгааг гаргаж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Усны тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт [үр нөлөөтэй](#) байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд тус ажлын хэсэг 1 ажлыг төлөвлөн хэрэгжүүлжээ. БОАЖЯ-ны дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас тус онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах [шаардлагагүй](#) гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад **нийцсэн** тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.9 сая төгрөгөөр буюу 10 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	4,544.9	4,544.9	-
Үндсэн хөрөнгө	11,460.5	27,449.2	15,988.7
Нийт хөрөнгө	16,005.4	31,994.1	15,988.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,005.4	31,994.1	15,988.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	16,005.4	31,994.1	15,988.7

Дээрх хүснэгтээс харахад Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,988.7 мянган төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймгийн Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны төсвийн төсөлд 2022 оны нийт зардлыг 184,571.6 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 184,571.6 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба дээд шатны төсвийн захирагч тус байгууллагад 184,571.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 184,571.6 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 184,026.1 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулагдаагүй 545.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 184,026.1 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн цалин 122,9 мянга, гэрэл цахилгааны зардлыг 110,7 мянга, томилолт, зочны зардлыг 311,8 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалжээ.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71404/80101-Усны нөөц гол мөрний менежмент	146,767.2	146,221.7	545.5	99.6
2	71404/80802-Тэтгэвэр, тэтгэмж	37,804.4	37,804.4	-	100.0
ДҮН		184,571.6	184,026.1	545.5	95.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар хог цэвэрлэгээний шатахууны 500,0 мянга, МоЭн Ко ХХК-наас усны дүгнэлтийн 200,0 мянган төгрөг орсон ба, дээрх эх үүсвэрийг зориулалтын дагуу шатахуун худалдан авахад зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор Ц.Аззаяа 2023 оны 01 дүгээр сарын 25-наас 01 дүгээр сарын 28-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 151.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Ховд аймгийн Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргаа нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд гэвэл тус байгууллага нь 2022 онд 3,813.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг 10 албан хаагчид олгосон байна. Энэ нь нягтлан бодогч тайлан тушаах ажлаар 241.0 мянган төгрөг, дарга, жолооч нар Улаанбаатар хотруу сургалт, автомашин хүлээж авах ажлаар автобусаар 131.0 мянган төгрөг, уст цэгийн мониторинг судалгаа хийх ажлаар 8 ажилтанд 1,424.0 мянган төгрөг, усны тоо бүртгэл, эвдэрсэн газрын тооллого хийх ажлаар 8 ажилтанд 1,296.0 мянган төгрөгийн томилолтыг тус тус олгожээ албан ажилтай холбоотой байна.

11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн хувьд Төрийн албаны тухай хуулийн 46.2.2-т зааснаар албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж нийт 37,804.4 мянган төгрөгийн тэтгэмжийг 1 албан хаагчид олгосон байна.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн хувьд холбоотой зардал гараагүй байна.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 159 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын зарим мэдээлэл мэдээлэгдээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг нөхөн мэдээлүүлж залруулсан болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн ТАГ-аас 2022 онд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн 0.8 сая төгрөгийн залруулга хийгдэж зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,360.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 алдааг залруулж 1,360.0 мянган төгрөгийн 1,360.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Залруулсан алдаа

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хэсэгт орлогын гүйлгээнд санхүүжилтийн орлогыг мэдээлээгүй байсныг нөхөж мэдээлүүлж 2023 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлэв.

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.4 Зөвлөмж

5.4.1 Нүүрсний зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 1,360.0 мянган төгрөгийн нүүрс худалдан авч зарцуулсан боловч зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, шаардах хуудсыг тухай бүр бичүүлээгүй, бөөн дүнгээр зарлагадсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг

баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Няравын ажлын хариуцлагыг сайжруулж, түлээ нүүрсний зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх.

5.4.2 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын хэрэгцээнд 2017 оноос хойш ашиглаж байгаа төслийн шугамаар ирсэн Пургон автомашиныг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, Ланд круйзер 79 авто машиныг 2022 оны 8 сараас хойш ашиглаж байгаа бөгөөд төрийн өмчийн хорооны шийдвэр гараагүй шалтгаанаар бүртгээгүй байна. Элэгдэл хэрхэн тооцох талаар тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", аудитын "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын хэрэгцээнд ашиглаж байгаа автомашинуудыг үндсэн хөрөнгөд бүртгэх талаар холбогдох эрх бүхий байгууллагад уламжилж шийдвэр гаргуулах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн		
Шилэн дансны цахим системд санхүүжилтийн мэдээллийг нөхөж мэдээллүүлсэн.	-	-	1.0	-	-	-	1.0	-	-	-	-	-
Дүн	-	-	1.0	-	-	-	1.0	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/ мянган төгрөг/							
	Үүнээс				Зөвлөмж			
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тайлант онд 1,360.0 мянган төгрөгийн нүүрс худалдан авч зарцуулсан боловч зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, шаардах хуудсыг тухай бүр бичүүгээгүй, бөөн дүнгээр зарлагдсан зөрчил илэрлээ.	1	1,360.0					1	1,360.0
Байгууллагын хэрэгцээнд 2017 оноос хойш ашиглаж байгаа төслийн шугамаар ирсэн Пургон автомашиныг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, Ланд круйзер 79 авто машиныг 2022 оны 8 сараас хойш ашиглаж байгаа бөгөөд төрийн өмчийн хорооны шийдвэр гараагүй шалтгаанаар бүртгээгүй байна. Элэгдэл хэрхэн тооцох талаар тодорхойгүй байна.	1	-					1	-
Дүн	2	1,360.0	-	-	-	-	2	1,360.00

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд санхүүжилтийн мэдээллийг нөхөж мэдээллүүлсэн.	1.0	-	-	-	-	-	-	-
Дүн	1.0							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Нийт дүн	1.0							

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А.БОЛДВААТАРАУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  Ц.АЗЗАЯА

Ц.АЗЗАЯА